



АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР  
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн  
албан тушаалын тодорхойлолтыг  
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 103.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1 дэх заалт, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрмийн 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эмч нарын албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, эмзүйч нарын тодорхойлолтыг хоёрдугаар, тасаг нэгжийн ахлах эх баригч/сувилагчийн тодорхойлолтыг гуравдугаар, эх баригчийн тодорхойлолтыг дөрөвдүгээр, цахим бүртгэл, лавлагаа мэдээллийн ажилтны тодорхойлолтыг тавдугаар, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний сувилагчийн тодорхойлолтыг зургаадугаар, мэс заслын сувилагчийн тодорхойлолтыг долоодугаар, дархлаажуулалтын сувилагчийн тодорхойлолтыг наймдугаар, нярайн сувилагчийн тодорхойлолтыг есдүгээр, цусны технологичийн ажлын байрны тодорхойлолтыг аравдугаар, лаборантын тодорхойлолтыг арваннэгдүгээр, туслах сувилагчийн тодорхойлолтыг арванхоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Шинэчлэгдсэн ажлын байрны тодорхойлолтыг мөрдүүлэн ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /С.Ганболд/, албадын дарга нар, эмчилгээ үйлчилгээний тасгийн эрхлэгч, арга зүйч нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн менежер /Б.Саранцэцэг/-д даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан амаржих газрын даргын 2015 оны А/40 дүгээр тушаал хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Ц.БАТБОЛД